

## МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалын код: 13.060.30

Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрүүдээс ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд нийлүүлэх урьдчилан цэвэршүүлсэн бохир ус. Техникийн шаардлага	MNS 6390 : 2013
The primary treated effluent of wool and cashmere factory into the sewerage of central treatment plant. Technical requirements	

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2013 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2013 оны 07 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын шаардлагыг заавал мөрдөнө.

### 1. Зорилго

Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрүүдийн ахуйн болон үйлдвэр, үйлчилгээ эрхлэлтээс гарсан урьдчилан цэвэршүүлсэн бохир усан дахь бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд агууламж болон үзүүлэлтийн хязгаарыг тогтооно.

### 2. Хамрах хүрээ

**2.1.** Энэхүү стандарт нь ноос, ноолуур боловсруулах үйлдвэрүүдийн ахуйн болон үйлдвэрлэлийн хэрэглээнээс гарсан бохир усыг урьдчилан цэвэршүүлж ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд нийлүүлэх үйл ажиллагаанд мөрдөнө.

**2.2.** Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрүүдээс ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд нийлүүлэх бохир усан дахь бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд агууламж болон үзүүлэлтэд мэргэжлийн байгууллагуудын хяналт тавих үйл ажиллагаанд мөрдөгдөнө.

### 3. Норматив эшлэл

Энэхүү стандартад эш татаж хэрэглэсэн дараах стандарт болон норматив техникийн баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд тэдгээрийн хамгийн сүүлчийн албан ёсны хэвлэлийг хэрэглэнэ. Үүнд:

- Стандарт бүтэц ба боловсруулах дүрэм MNS 1-2 : 2006;
- Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологийн түвшинд тавигдах үндсэн шаардлага. MNS 4288-1995;
- Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага. MNS 4943:2011;
- Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрт тавигдах Ерөнхий шаардлага MNS 5563:2005;
- Ус хангамж, ариун цэврийн байгууламж. Нэр томъёо, тодорхойлолт-тайлбар толь MNS 6279:2011;
- Бохир ус зайлуулах цэг тогтоох. Ерөнхий шаардлага MNS 6230:2010;
- Үйлдвэрлэлийн технологи хаягдал. Зумласан ноос MNS 5251:2008;

## **MNS 6390 : 2013**

- Умбуур бодисыг шилэн судалт шүүлтүүрээр шүүж тодорхойлох MNS ISO 11923:2001;
- Химийн хэрэгцээт хүчилтөрөгчийг тодорхойлох. MNS ISO 6060:2001;
- Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгчийг тодорхойлох. MNS ISO 5818:2001;
- Арьс ширний үйлдвэрийн технологийн хаягдал усанд сульфид тодорхойлох арга. MNS 5597:2006;
- Хлоридын агууламжийг тодорхойлох. Хромат илрүүлэгчийн оролцоотойгоор мөнгөний нитратаар титрлэх. MNS ISO 9297:2005;
- Кьелдалийн азот тодорхойлох. Селений оролцоогоор эрдэсжүүлсний дараах арга. MNS ISO 5663:2001;
- рН-ийг тодорхойлох. MNS ISO 10523:2001;
- Ариутгах татуурга, гадна сүлжээ ба байгууламж. БНБД. 40.01.06;
- Бохир ус зайлуулах төвлөрсөн сүлжээнд нийлүүлэх үйлдвэрийн бохир усны найрлагын зөвшөөрөгдөх хэмжээ. Дэд Бүтцийн Хөгжлийн Сайд, Байгаль Орчны Сайд, Эрүүл Мэнд, Нийгмийн Хамгааллын Сайдын 1997 оны а/11/05/А/18 тоот тушаал;
- Усны тухай хууль /2012-05-17/;
- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль /2012-5-17/.

### **4. Нэр томъёо, тодорхойлолт**

#### **4.1. Урьдчилан цэвэрлэх байгууламж**

Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрүүдийн технологи ажиллагаанаас гарч буй хаягдал усыг ариутгах татуургын төвлөрсөн сүлжээний шаардлагын түвшинд хүртэл цэвэршүүлэх зориулалттай барилга байгууламж, техник, технологи, ажиллах хүчний цогцолбор.

#### **4.2. Хаягдал ус**

Ахуйн хэрэглээ болон үйлдвэрлэл, үйлчилгээнээс гарч байгаа бохир ус, шингэн хаягдал.

#### **4.3. Цэвэршүүлсэн ус**

Хаягдал усны найрлага дахь бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд агууламж болон үзүүлэлтүүдийн хязгаарыг тогтоосон хүснэгтэд заасан хэмжээнд хүртэл цэвэршүүлэн ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд нийлүүлэх бохир ус.

### **5. Ерөнхий шаардлага**

**5.1.** Үйлдвэр бүр хаягдал усыг цэвэрлэх зориулалттай урьдчилан цэвэрлэх байгууламж, дотоодын лабораторитай эсвэл цэвэрлээд гаргаж буй усны химийн бохирдолтыг хэмжиж байдаг суурин хэмжих тоног төхөөрөмжтэй байна.

**5.2.** Энэ стандартын шаардлагыг хангаагүй хаягдал усыг ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд нийлүүлэхийг хориглоно.

**5.3.** Үйлдвэрээс ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд нийлүүлж буй урьдчилан цэвэршүүлсэн бохир усны чанарын үзүүлэлтүүдийг сар бүр итгэмжлэгдсэн лабораториор тодорхойлуулах ба мэргэжлийн хяналтын байцаагчийн дүгнэлт гаргуулж байх.

**5.4.** Ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд нийлүүлж буй бохир усны найрлагад энэхүү стандартад заагдаагүй хортой бодис илэрвэл уг бодисын хэмжээг энэ стандартын норматив эышлэлд дурьдсан стандарт болон норматив техникийн баримт бичигт заагдсан зөвшөөрөгдөх хэмжээгээр тооцно. Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрүүдийн ахуйн болон үйлдвэр, үйлчилгээ эрхлэлтээс гарсан урьдчилан цэвэршүүлсэн бохир усан дахь бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь “Бохир ус зайлуулах цэг тогтоох” MNS 6230:2010 стандартын хавсралт А-д заасан шаардлагад нийцсэн байх ба MNS 5251:2008 стандартын түүхий эд угааж байгаа үйлдвэрүүд MNS 4288:1995 стандартын 2.13 болон 2.14 заалтуудыг мөрдөж ажиллана.

**5.5.** Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрүүдээс ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд нийлүүлэх урьдчилан цэвэршүүлсэн бохир усан дахь бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд агууламж ба үзүүлэлтүүдийн хязгаарыг 1-р хүснэгтэд зааснаар тогтооно.

1-р хүснэгт

**Цэвэршүүлсэн бохир усан дахь бохирдуулах  
бодисын зөвшөөрөгдөх дээд агууламж ба бусад үзүүлэлтийн хязгаар**

№	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Зөвшөөрөгдөх дээд агууламж ба хязгаар
1	Жинлэгдэх бодис	мг/л	400.0
2	Био химийн хэрэгцээт хүчил төрөгч	мг/л	400.0
3	Химийн хэрэгцээт хүчил төрөгч	мг/л	800.0
4	Сульфид	мг/л	10.0
5	Хлорид	мг/л	900.0
6	Бүх төрлийн угаагч бодис	мг/л	10.0
7	Нийт азот	мг/л	30.0
8	Амьтан, ургамлын гаралтай тос	мг/л	20.0
9	Аммиак	мг/л	15.0
10	Хөх будагч (синтетик)	мг/л	25.0
11	Хүрэн будагч (хүхэрт будаг)	мг/л	0.5
12	Хөнгөн цагаан	мг/л	0,5
13	Усны орчин, рН	-	6.5-8.5

## 6. Лабораторийн шинжилгээ

Хаягдал усан дахь бохирдуулах бодисын агууламжийг эшлэлд дурьдсан стандарт, шинжилгээний арга, аргачлалаар тодорхойлно.

**ТӨГСӨВ.**